

“АХМАДАА ДЭМЖИХ-2017” ОНЫ ЗОРИЛТОТ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

ЗОРИЛГО: Ахмад тамирчдын залгамж халааг бэлтгэх, сурталчлах, настануудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, тэднийг нийтийн биеийн тамирт татан оролцуулах, шинээр хөгжиж буй спортыг олон нийтэд сурталчлан таниулах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор доорх ажлуудыг төлөвлөн ажиллаа.


- 35-аас дээш насны иргэдийн судалгаа хийх
- Ахмад тамирчдыг алдаршуулах, сурталчлах тэмцээн уралдаан зохион байгуулах
- Олон улс, Улс, ААШ, сумын аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулах, оролцох
- Зорилтот жилийн урлаг. спортын наадмыг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж ажиллах
- Монголын мастеруудын III их наадмыг зохион байгуулах
- Үр дүнг хянах

Өвөрхангай аймгийн газар нутгийн байдал, хүн амын тоо



❖ 2016 оны байдлаар Өвөрхангай аймгийн хүн амын нийт тоо 113.911 мянга үүний 40359 буюу 35,4 % нь 35-аас дээш насны иргэд байна.


❖ Өвөрхангай аймгийн 35-аас дээш насны /хүйс/ ангилалаар нь графикаар үзүүлбэл



Өвөрхангай аймгийн 35-аас дээш насны иргэдийн тоон судалгаа /2016 оны байдлаар/

Нас	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
35-39	4180	3937	8117
40-44	3788	3954	7742
45-49	3256	3535	6791
50-54	2739	3030	5769
55-59	1878	2248	4126
60-64	1168	1524	2692
65-69	713	953	1666
70-аас дээш	1305	1960	3265
Нийт хүн амын тоо	18998	21361	40359

19 сумын 35-аас дээш насны иргэдийн график



35-ААС ДЭЭШ НАСНЫ ИРГЭДИЙН СУДАЛГАА

Д/д	Сум	Насны ангилал								Хүйс		Бүгд
		35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70-аас дээш	эрэгтэй	эмэгтэй	
1	Арвайхээр	2195	2089	1854	1554	1054	665	453	931	4858	5937	10795
3	Баян-Өндөр	281	255	219	193	139	111	58	150	683	723	1406
2	Бүрд	244	207	157	145	113	78	57	111	539	573	1112
4	Бат-Өлзий	524	484	441	371	228	142	66	140	1166	1230	2396
5	ББУлаан	190	159	152	129	85	53	28	72	368	500	868
6	Баянгол	322	274	269	211	157	89	54	99	717	758	1475
7	Гучин-Ус	162	153	108	101	81	52	31	42	336	394	730
8	Есөнзүйл	230	198	173	149	126	71	64	101	539	573	1112
9	Өлзийт	198	157	137	131	82	64	56	105	456	474	930
10	ЗБУлаан	293	264	233	219	167	116	54	84	713	717	1430
11	Богд	406	340	301	230	151	97	51	105	773	908	1681
12	Нарийнтээл	257	236	239	217	149	77	48	82	637	668	1305
13	Сант	244	254	221	175	145	80	51	104	611	663	1274
14	Тарагт	232	258	200	180	125	96	49	95	625	610	1235
15	Төгрөг	208	203	161	124	94	61	27	77	444	511	955
16	Уянга	748	633	518	413	298	188	106	170	1444	1630	3074
17	Хайрхандулаан	267	253	229	165	115	97	60	88	621	653	1274
18	Хужирт	452	430	394	336	300	203	113	250	1167	1311	2478
19	Хархорин	838	895	785	727	520	355	250	459	2301	2528	4829
НИЙТ ДҮН		8291	7742	6791	5770	4129	2695	1676	3265	18998	21361	40359

Зорилтот жилийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинээр хөгжиж буй спортыг хөгжүүлэх, сурталчлах зорилгоор манай байгууллага нь “ХӨДӨЛГӨӨНӨӨР ГАНГАРЬЯ ӨВӨРХАНГАЙЧУУД АА” уриалга гарган ахмад иргэдийн дунд /“Софт волейбол”, “Хийн дасгал”, “Граунд гольф”/ гэсэн 3-н төрлөөр үнэ төлбөргүй Спортын ордонд хичээллүүлж эхэлсэн.



Монголын мастеруудын биеийн тамир, спортын салбар хороо байгуулж орон нутгийн санхүүжилтээр шинээр хөгжиж буй спортын хэрэглэл материалтай болсон. Үүнд: Софт волейбол, Граунд гольфын иж бүрэн хэрэгсэлтэй болсон.



ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

Зорилтот жилийн ажлын хүрээнд жилийн эцсийн байдлаар зохион байгуулсан арга хэмжээнд нийт 36 байгууллага, аж ахуйн нэгжүүд 16 удаагийн арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 5346 ахмад иргэд хамрагдсан байна.

ММБТСХорооны Ерөнхийлөгч Ч.Наранбаатарыг урьж ахмад настануудын дунд сургалт зохион байгуулсан. Сургалтанд УБ хотод шинээр байгуулагдсан холбооны үйл ажиллагааг танилцуулж Монгол улсад шинээр хөгжиж буй Софт волейбол, Граунд гольфын спортын төрлүүдийг танилцууллаа. Тус сургалтанд Арвайхээр сумын 11 багийн 94 ахмад хамрагдсан. Энэ сургалт маш ач холбогдолтой сургалт болсон үүний явцад шинээр аймаг орон нутагтаа Граунд гольфын холбоо байгуулсан.



Сургалтын үеэр Граунд гольфын тэмцээн зохион байгуулж явуулсан тэмцээнд засаг даргын орлогч О.Батжаргал хүрэлцэн ирж оролцсон



Шагналт байранд орсон тамирчид



Граунд гольфын холбоо байгуулж тэргүүнээр аймгийн засаг даргын орлогч О.Батжаргал сонгогдон ажиллаж байна. Тус холбоо нь энэ оны 4-р сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Бэлтгэлийн цаг нь өглөөний 07.00-09.00 хүртэл орой 19.00-21.00 цаг хүртэл тамирчид хээрийн талбай, хөл бөмбөгийн талбайд ирж хийдэг байсан. Холбоо байгуулагдсанаас хойш аймаг, бүс, олон улсын тэмцээнд амжилттай сайн оролцсон.

ГРУАНД ГОЛЬФЫН БЭЛТГЭЛИЙН ҮЕИЙН ЗУРГАНААС



- МУ-ын спортын мастер БТСТэргүүний ажилтан Улсын бөх тайлбарлагч Д.Буянтогтохын нэрэмжит чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 21 багийн 301 тамирчид охидын 10 хөвгүүдийн 12 жинд ур чадвар, авхаалж самбаагаа сорин барилдлаа.



- “Ахмадаа дээдлэх жил”-ийн ажлын хүрээнд БТСГ-ын ахмад ажилтан Өвөрхангай аймгийн Төгрөг сумын уугуул Волейболын спортын ОУХМастер, аймгийн арслан С.Доржваанчигийн нэрэмжит волейболын тэмцээнийг 2017 оны 04 сарын 29-30-ны өдрүүдэд ММБТС-ын ӨВ салбар хороо,Төгрөг сумтай хамтран амжилттай зохион байгуулж явууллаа. Тэмцээнд 25 багийн эрэгтэй 12, эмэгтэй 13 баг 150 тамирчид өрсөлдсөнөөс

Тэмцээнд эрэгтэй эхний байруудад:

- 1-р байр М.Батбаяр дасгалжуулагчтай Намгилрагчаа ахлагчтай Гучин-Ус сум
- 2-р байр Б.Нармандах ахлагчтай Тарагт сум
- 3-р байр Б.Батболд ахлагчтай Хархорин сум



- Зүүнбаян-Улаан сумын уугуул Монгол улсын байт сурын анхны гавъяат тамирчин, аймгийн дархан мэргэн үндэсний сурын нэрт зүтгэлтэн Г.Бямбаагийн нэрэмжит аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг аймгийн БТСГазар, ЗБУлаан сумын УБ хот дахь нутгийн зөвлөл, түүний үр хүүхдүүд, шавь нартай нь хамтран энэ оны 05 сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тэмцээнд оролцогсдын 28 нь насанд хүрэгчид, 18 нь өсвөрийн харваачид байлаа. Өсвөрийн харваачдын ур чадварыг дээшлүүлэх тэдэнд урам зориг хайрлах зорилгоор өсвөр үеийн харваачдыг 2 насны ангилалаар зохион байгууллаа. Тэмцээнд нийт 46 харваачид оролцлоо.



- ОУХМастер Д.Амарсанаагийн нэрэмжит намрын тэргүүн шалгаруулах хөнгөн атлетикийн өсвөр үеийн тэмцээнийг 09-р сарын 21-22-ны өдрүүдэд Арвайхээр суманд зохион байгууллаа. Тэмцээнийг 14-15 нас, 16-17 нас гэсэн ангиллаар 14 багийн 199 тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс **Багийн дүнгээр:** 14-15 насанд: 1-р байр Б.Мягмаржав дасгалжуулагчтай Уянга сумын 2-р сургууль, 2-р байр Б.Ганхуяг дасгалжуулагчтай Бат-Өлзий сум, 3-р байр Ц.Отгонбямба дасгалжуулагчтай Арвайхээр сумын 1-р сургууль, 16-17 насанд: 1-р байр Цэвэлдорж дасгалжуулагчтай Хархорин сумын Спортын ордон, 2-р байр Б.Ганхуяг дасгалжуулагчтай Бат-Өлзий сум, 3-р байр Гүнсэнхорол дасгалжуулагчтай Арвайхээр сумын 2-р сургуулиуд тус тус эхний байруудад шалгарч өргөмжлөл, меадль мөнгөн шагналаар шагналдаа.



Нийтийн цэнгээт бүжгийг сурталчлах хөдөлгөөний хомсдлоо сурьдчлан сэргийлэх зорилгоор ахмад иргэдийн дунд арвайхээр сумын ахмадын хороотой улирал бүр зохион байгуулж хамтран ажиллаа.



Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах тэдний нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, мэдлэг туршлагыг нь хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээх зорилгоор аймгийн ИТХурлаас 2017 оны “Ахмадаа дээдлэх” жил болгон зарласантай холбогдуулан орон нутгийн төсвийн хөрөнгө 867,0 сая төгрөгөөр шинэ “Ахмадын өргөө” байгууллаа. Энэхүү өргөө ашиглалтанд орсоноор ахмад настануудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэднийг нийтийн биеийн тамирт татан оролцуулах, шинээр хөгжиж буй спортыг сурталчилах, нийтийн цэнгээт бүжиг, хийн дасгалыг хийж хэвшүүлэх зэрэг томоохон үйл ажиллагаа явуулахад таатай орчин бүрдсэн.



Арвайхээр сумын аварга шалгаруулах Софт волейболын анхдугаар тэмцээний тайлан

Ахмадаа дэмжих жилийн ажлын хүрээнд ММБТСпортын Өвөрхангай аймгийн салбар хорооноос санаачлан зохион байгуулж буй анхны ахмадын холимог Софт волейболын Арвайхээр сумын аварга шалгаруулах тэмцээнийг ахмад настануудын чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, тэднийг нийтийн биеийн тамирт татан оролцуулах, цаашлаад Аймгийн аварга, Улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд оролцох тамирчдыг сонгон шалгаруулахад зорилгоор энэхүү тэмцээнийг 2017 оны 04 сарын 09-ны өдөр Спортын ордонд амжилттай зохион байгууллаа.

Тэмцээний үйл ажиллагааг нээж Арвайхээр сумын засаг даргын орлогч н.Хоролгарав БТСГ-ын дарга Б.Энхтөр нар үг хэлж энэхүү арга хэмжээг нээлээ. Нээлтийн үеэр ММБТСХорооны гишүүнчлэлийн үнэмлэхийг 12 идэвхтэй ахмад тамирчинд гардуулж өглөө.

Тэмцээний ерөнхий шүүгчээр БТСГ-ын НБТ арга зүйч ММБТСпортын ӨВ аймгийн салбар хорооны тэргүүн Ч.Оюунсүрэн

Нарийн бичиг шүүгчээр БТСГ-ын НБТ арга зүйч С.Түмэндэмбэрэл, ММБТСпортын ӨВ аймгийн салбар хорооны нарийн бичгийн дарга Р.Лхагвасүрэн

Талбайн шүүгчээр ММБТСпортын ӨВ аймгийн салбар хорооны тэргүүлэгчид дэд хурандаа Д.Очирбал, жагсаалын дарга Б.Ганбаатар, дэд хурандаа Б.Сайнбилэг нарын шүүгчид шүүн явууллаа.

Тэмцээнийг 3 насны ангилалаар Арвайхээр сумын 9-н байгууллагын иргэдийн 23 багийн 138 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа дайчлан өрсөлдсөнөөс:

40-49 насны ангилалд: 1- байр Рашаантын 8-р баг

2-р байр Ноёны 10-р баг

3-р байр Арвайхээр сумын 5-р баг

50-59 насны ангилалд: 1-р байр Арвайхээр сумын 5-р баг

2-р байр Дэлгэрэх дэнжийн 7-р баг

3-р байр Эмтийн 2-р баг

60-аас дээш насны ангилалд: 1-р байр Арвайхээр сумын 5-р баг

2-р байр Дэлгэрэх 3-р баг

3-р байр Ноёны 10-р баг тус тус эзэлж өргөмжлөл, медаль шагнаж урамшууллаа.

Тус тэмцээнийг баг онооны системээр дүгнэн нийлбэр дүнгээр

1-р байр Д.Буянтогтох ахлагчтай Арвайхээр сумын 5-р баг /80,000төг/

2-р байр Д.Лхүмбэ ахлагчтай Рашаантын 8-р баг /60,00төг/

3-р байр Б.Бямбахорол ахлагчтай Дэлгэрэхийн 3-р баг /50,000төг/ тус тус эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав.

Энэхүү тэмцээн нь анх зохион байгуулагдсан гэхэд нийлээд олон иргэд хамрагдсан маш өргөн хүрээтэй арга хэмжээ боллоо.

Цаашлаад Софт волейболын төрлийг орон нутагтаа өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн дунд өргөнөөр хөгжүүлэх дур сонирхолтой болгох зорилгоор энэхүү арга хэмжээг улиралд нэг удаагийн тэмцээн уралдаан зохион байгуулах ажлыг өрнүүлэх болно.

Шагналт байранд орсон тамирчдын зураг



Софт волейболын ААШТэмцээний тайлан

Өвөрхангай аймгийн анхдугаар Софт волейболын ААШ тэмцээнийг ММБТС-ын Өвөрхангай аймаг дахь салбар хороо, БТСГазар, Аймгийн волейболын холбоотой хамтран зохион байгуулж явууллаа.

Тэмцээний нээлтийн арга хэмжээнд Өвөрхангай аймгийн засаг даргын орлогч О.Батжаргал, ММБТСХорооны ерөнхийлөгч, МУГДасгалжуулагч Ч.Наранбаатар, аймгийн засаг даргын дэргэдэх БТСГ-ын дарга Б.Энхтөр, ММБТС-ын ӨВ салбар хорооны тэргүүн Ч.Оюунсүрэн нар оролцлоо.



Тэмцээний нээлтийн үеэр ЗХ-ний 256-р ангийн үлээвэр найрал хөгжим, СӨББ-ын 4-р цэцэрлэгийн Уран хөдөлгөөнт гимнастикийн 2 дахь удаагийн аймгийн аварга хүүхдүүд, 9-р цэцэрлэгийн дуу хөгжмийн багш Данайжав нар ахмад тамирчдад амжилт хүсэж мэндчилгээ дэвшүүллээ.

Тэмцээнийг 35-аас дээш 3-н насны ангилалаар зохион байгуулж тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа дайчлан өрсөлдлөө. Тэмцээнд 17 багийн 102 тамирчин өрсөлдсөнөөс:

60-аас дээш насны ангилалд:

1-р байр: Ц.Нямтогтох ахлагчтай “УБ хотын багш нарын” баг тамирчид

2-р байр: С.Доржваанчиг ахлагчтай “Монгол засвар” баг тамирчид

3-р байр: О.Долгорсүрэн ахлагчтай “Хархорин” сумын баг тамирчид



50-59 насны ангилалд:

1-р байр: Д.Пүрвээ ахлагчтай “Хархорин” сумын баг тамирчид

2-р байр: Ж.Эрдэнэбат ахлагчтай “БТСГазрын” баг тамирчид

ЧЗ-р байр: Д.Эрдэнэчулуун ахлагчтай “Богд” сумын баг тамирчид



40-49 насны ангилалд:

1-р байр А.Хүүхнээ ахлагчтай “БТСГазрын” баг тамирчид

2-р байр Ц.Батсайхан ахлагчтай “Хархорин” сумын баг тамирчид

3-р байр Г.Ганхуяг ахлагчтай “Түшиг” баг тамирчид



тус тус эзэлж цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав. Тэмцээний үеэр уралдаан тэмцээнд идэвхи санаачлагтай оролцдог тамирчдад ММБТСХорооны ерөнхийлөгч, МУГДасгалжуулагч Ч.Наранбаатар ММБТС-ын хорооны шагналаар шагнаж урамшуулав.

ТЭМЦЭЭН УРАЛДААНД ОРОЛЦСОН БАЙДАЛ

Ахмадаа дэмжих жилийн ажлын хүрээнд жилийн эцсийн байдлаар . . . удаагийн томоохон арга хэмжээнд нийт . . . тамирчид хамрагдсан байна.

- Ахмадаа дэмжих жилийн ажлын хүрээнд ахмад настануудын дунд Монголын мастеруудын биеийн тамир, спортын хорооны нэрэмжит Софт волейболын ахмадын тэмцээн УБ хотноо 2017 оны 2-р сарын 17-ны өдөр ХАСУ Мегаватт спорт цогцолборт 2 өдрийн турш 3 насны ангилалаар 27 багийн 160 тамирчин оролцсон тэмцээнд манай аймгийн тамирчид 5-н багийн бүрэлдэхүүнтэй оролцож, 35-49 насныхан аваргын төлөө Дархан-Уул аймагтай тоглож дэд байр, 50-59 насныхан Архангай аймагтай аваргын төлөө тоглож дэд байр тус тус эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа. Тэмцээний нээлтийн үеэр манай аймгийн ахмад тамирчин Р.Лхавгасүрэнг "Алтан од" медиалаар шагналаа.
- Ахмадын Софт волейболын УАШалгаруулах тэмцээнд манай аймгаас 4 баг оролцож 40-49 нас Мөнгө, 50-59 нас Алтан медалийн болзол хангаж амжилттай сайн оролцлоо.
- Нийтийн биеийн тамир, шинээр хөгжиж буй спортыг орон нутагтаа хөгжүүлэх ажлыг өргөжүүлэхээр, туршлага судлах зорилгоор Архангай аймагт болсон бүсийн аварга шалгаруулах Граунд гольфын тэмцээнд 10 хүний бүрэлдэхүүнтэй оролцож 5 багийн 50 тамирчид хамрагдсанаас 2-р байранд шалгарч амжилттай оролцсон. Мөн хувийн амжилтаар байр эзлүүлж алтан бөмбөгний эзэнээр 2 тамирчин шалгарсан.



- Төв аймагт зохион байгуулагдсан Олон улсын Граунд гольфын тэмцээнд 9 орны тамирчид оролцож, орон нутгаасаа 15 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдаж, алтан бөмбөгний эзэн 4, мөнгө 1, хүрэл 2 медаль тус тус хүртэж амжилттай оролцсон.





- Улсын аварга шалгаруулах хөнгөн атлетикийн тэмцээнд 2 тамирчин оролцож зэрэнцэг бөөрөнцөгийн төрөлд алт, мөнгөн медаль, 100м төрөлд мөнгөн медалийн болзол хангаж амжилттай оролцсон



Аймгийн “Ахмадаа дэмжих-2017” зорилтот жилийн урлаг, спортын наадмын тайлан

“Ахмадаа дээлэх жил-2017” Зорилтот жилийн ажлын хүрээнд зохион байгуулж ажиллах комиссын шийдвэрээр урлаг, спортын их наадмыг аймгийн хэмжээнд 3-н үе шаттайгаар 6-н бүс болгон хувааж спортын 5-н төрлийн тэмцээнийг хамтран зохион байгуулж ажиллаа. Тус наамдыг өндөр түвшинд зохион байгуулж ажиллах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй ажиллаа.

- Аймгийн засаг даргын орлогч ажлын хэсгийн ахлагч О.Батжаргал
- Нарийн бичгийн даргаар: НБХэлтсийн дарга Б.Мөнхжаргал
- Гишүүд: Ахмадын хорооны дарга Д.Баяртогтох
- НБХэлтсийн мэргэжилтэн Б.Бүзмаа
- Ахмад сэтгүүлч Мөнхдалай

Спортын төрлийг: А.Хүүхнээ
Ч.Оюунсүрэн
Г.Цэнд-Аюуш
Н.Дорж

Урлагийн төрлийг: Д.Ганбаатар
А.Энхцэцэг
Г.Батбаатар

Их наадмыг 6-н бүс болгон хувааж спортын 5-н төрөл, урлагийн 6-н төрлөөр 40-өөс дээш насны ахмад тамирчид өрсөлдлөө.

- Арвайхээр 1-р бүс
- Хархорин 2-р бүс
- Бүрд, Баян-Өндөр, Есөн-Зүйл, Сант, Өлзийт 3-р бүс
- Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга, Тарагт 4-р бүс
- Хужирт, Бат-Өлзий, ЗБУлаан 5-р бүс
- Богд, Гучин-Ус, Баянгол, Төгрөг, ББУлаан 6-р бүс

Нийт арга хэмжээнд спортын төрөлд давхардсан тоогоор 1054 ахмад тамирчид оролцсон байна.

Нэгдүгээр бүс: Арвайхээр сумын ЗДТГазартай хамтран 2017 оны 05 сарын 05-06-ны өдрүүдэд 11-н багуудын дунд зохион байгуулж явууллаа. Тэмцээнд 11 багийн 594 тамирчин спортын 5-н төрлөөр өрсөлдөө.

Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа



Хийн дасгалын төрөлд:

- 1-р байр Ц.Шийлэгдолгор ахлагчтай Арвайхээрийн 5-р баг
- 2-р байр Ц.Цэцэгмаа ахлагчтай Согоотын 1-р баг
- 3-р байр Р.Цэрэндэгд ахлагчтай Дэлгэрэх дэнжийн 7-р баг



Волейболын төрөлд: 60-дээш нас:

- 1-р байр С.Доржваанчиг ахлагчтай Арвайхээрийн 5-р баг
- 2-р байр Г.Чүлтэм ахлагчтай Ноёны 10-р баг
- 3-р байр З.Дашзэвэг ахлагчтай Эмтийн 2-р баг

50-59 нас

- 1-р байр Б.Сайнбилэг ахлагчтай Арвайхээрийн 5-р баг
- 2-р байр О.Баатарсүрэн ахлагчтай Их-Уул Ягаан толгойн 6-р баг
- 3-р байр С.Пүрэв ахлагчтай Дэлгэрэх дэнжийн 7-р баг

40-49 нас

- 1-р байр Т.Алимаа ахлагчтай Эмтийн 2-р баг
- 2-р байр Б.Энхтөр ахлагчтай Арвайхээрийн 5-р баг
- 3-р байр Б.Болдбаатар ахлагчтай Бурхийн 9-р



Ширээний теннисний төрөлд:

Эрэгтэй: 40-49 нас

Эмэгтэй 40-49 нас

1-р байр А.Хүүхнээ /Арвайхээр 5-р баг/
2-р байр Д.Чулуунбат /Дэлгэрэхийн 3-р баг/
3-р байр Д.Баяраа /Ноёны 10-р баг/

Эрэгтэй 50-59 нас

1-р байр Даваадавга /Эмтийн 2-р баг/
2-р байр Равжир /Өлзийт 4-р баг/
3-р байр Г.Баттулга /Арвайхээр 5-р баг/

60-аас дээш нас

Эрэгтэй 1-р байр Ц.Төмөр-Очир /Бурхийн 9-р баг/
2-р баг Раднаа /Рашаантын 8-р баг/
3-р байр Пүрэв /Дэлгэрэх дэнжийн 7-р баг/

Эмэгтэй 1-р байр С.Бүзмаа /Дэлгэрэхийн 3-р баг/
2-р байр Пүрэвдулам /Бурхийн 9-р баг/
3-р байр Алтанцэцэг /Арвайхээр 5-р баг/

1-р байр Энх-Отгон /рашаантын 8-р баг/
2-р байр Гантулга /Дэлгэрэхийн 3-р баг/
3-р байр Олонбаяр / Арвайхээр 5-р баг/

Эмэгтэй 50-59 нас

1-р байр М.Цэвээндулам /Согоотын 1-р баг/
2-р байр Ц.Нарантуяа /Бурхийн 9-р баг/
3-р байр А.Түмэннаст /Эмтийн 2-р баг/



Шагайн харвааны төрөлд:

- 1-р байр Мөнхтогтох, Эрдэнэбилэг
- 2-р байр Бат-Эрдэнэ, Бат-Очир
- 3-р байр Баярсайхан, Пүрэвдаваа



Шатрын төрөлд:

40-49 нас эмэгтэй

- 1-р байр Ц.Одсүрэн /7-р баг/
- 2-р байр Д.Жимсгэнэ /6-р баг/
- 3-р байр С.Регжимаа /5-р баг/

40-49 нас эрэгтэй

- 1-р байр Ж.Ганболд /4-р баг/
- 2-р байр А.Төртогтох /2-р баг/
- 3-р байр А.Даваасүрэн /1-р баг/

50-59-аас дээш нас эмэгтэй

- 1-р байр Ж.Маяасүрэн /5-р баг/
- 2-р байр И.Бат-Очир /1-р байр/
- 3-р байр Ц.Цэдэнпил /3-р баг/

50-59-аас дээш нас эрэгтэй

- 1-р байр Г.Дамба /4-р баг/
- 2-р байр Ц.Мягмарсүрэн /2-р баг/
- 3-р байр И.Равдан /5-р баг/



Тэмцээний багийн нийт дүнгээр:

- 1-р байр Б.Буянтогтох ахлагчтай Арвайхээрийн 5-р баг
- 2-р байр Бурхийн 9-р
- 3-р байр Эмтийн 2-р баг баг тус тус эзэлж тэргүүн байранд орсон тамирчид 3-р шатны шигшээ тэмцээнд оролцох эрхийн бичгээ гардан авлаа.

Хоёрдугаар бүс /Хархорин/: Бүсийн аварга шалгаруулах ахмадын тэмцээнд нийт 889 тамирчид хамрагдсан байна

Нээлтийн үйл ажиллагааны зураг /Хархорин/



Тэмцээний үеийн зураг



Урлаг, спортын тэмцээний хаалт



Гуравдугаар бүс: Хужирт, Бат-Өлзий, Зүүнбаянулаан 3 сумын нийт 165 тамирчид Хангай бүсийн нээлт



- 1-р байр Хужирт сум
- 2-р Бат-Өлзий сум
- 3-р байр ЗУБлаан сумын баг тамирчид

Хангай бүсийн тэмцээний үеийн зураг



Шагнал гардуулах ёслолын ажиллагаа



Дөрөвдүгээр бүс /Баруун бүс/: Уянга, Тарагт, Нарийнтээл, Хайрхандулаан 4 сумын нийт 214 тамирчид



- 1-р байр Уянга сум
- 2-р байр Нарийнтээл сум
- 3-р байр Хайрхандулаан сумын баг тамирчид

Тавдугаар бүс /Говийн бүс/: Гучин –Ус, Баянгол, Төгрөг, Богд, ББУлаан нийт 255 тамирчид

- 1-р байр Гучин-Ус сум
- 2-р байр Төгрөг сум
- 3-р байр ББУлаан сум

НЭЭЛТ





Зургаадугаар бүс: Зүүн бүс: Есөн-Зүйл, Бүрд, Өлзийт,

-
- 1-р байр Сант сум
- 2-р байр Бүрд сум
- 3-р байр Есөн-Зүйл сумын баг тамирчид тус тус хамрагдлаа Сант, Баян-Өндөр нийт 255 тамирчид тус тус хамрагдлаа.





Тэмцээний хаалт



“Ахмад-2017” зорилтот жилийн шигшээ тэмцээний тайлан

“Ахмад-2017” Зорилтот жилийн их наадмын нээлтийн үйл ажиллагаа 2017 оны 09 сарын 29-ны өдөр Арвайхээр сумын Аюушбаатарын талбайд ёслол төгөлдөр эхэллээ. Наадмын нээлтэнд Өвөрхангай аймгийн Засаг дарга ноён Г.Ганболд, Засаг даргын орлогч, зорилтот жилийн ажлын хэсгийн дарга ноён О.Батжаргал, Ахмадын хорооны дарга Д.Баяртогтох ажлын хэсгийн дарга нар болон үе үеийн ахмад тамирчид арга хэмжээг нээж үг хэллээ.



Тус наадамд 19 сумаас шалгарсан ахмадууд оролцлоо. Тэмцээнд 6 бүсийн нийт 462 ахмад тамирчин хамрагдаж үүнээс спортын 5 төрөлд 330 ахмад хурд хүч, авхаалж самбаагаа дайчлан өрсөлдөж нийлбэр дүнгээр:

Спортын төрөлд:

- Төвийн бүс 28 оноогоор 1-р байр
- Хангай бүс /Хархорин сум/ 38 оноогоор 2-р байр
- Говийн бүс 54 оноогоор 3-р байр

Урлагийн төрөлд:

- Төвийн бүс 16 оноогоор 1-р байр
- Хангайн бүс /Хужирт, Бат-Өлзий, ЗБУлаан/ 16 оноогоор 2-р байр
- Говийн бүс 16 оноогоор 3-р байр

Урлаг, спортын нийлбэр дүнгээр:

- Төвийн бүс /Арвайхээр/ 1-р байр 700,000 төгрөг
- Хангайн бүс /Хужирт, Бат-Өлзий, ЗБУлаан/ 2-р байр 600,000 төгрөг
- Говийн бүс /Гучин-Ус, Богд, Төгрөг, Баянгол, ББУлаан/ 3-р байр 500,000 төгрөг/ тус тус эзэлж Цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Тэмцээний төрөл тус бүрт:

Волейболын төрөлд:

40-49 нас

- 1-р байр Л.Мөнхнасан ахлагчтай Хархорин сум
- 2-р байр Б.Энхтөр ахлагчтай Арвайхээр сум
- 3-р байр Д.Баттогтох ахлагчтай Нарийнтээл сум



50-59 нас

- 1-р байр Д.Пүрвээ ахлагчтай Хархорин сум
- 2-р байр Ж.Эрдэнэбат ахлагчтай Арвайхээр сум
- 3-р байр Ц.Баярсайхан ахлагчтай Төгрөг сум



60-аас дээш нас

- 1-р байр Г.Хоролдорж ахлагчтай Хархорин сум
- 2-р байр Д.Халимаг ахлагчтай Гучин-Ус сум
- 3-р байр С.Дорваанчиг ахлагчтай Арвайхээр сум



11 Ширээний теннис төрөлд:

40-49 насны эрэгтэй

- 1-р байр А.Хүүхнээ Арвайхээр сум /70,000 төг/
- 2-р байр Р.Ууганбаяр Бат-Өлзий сум /60.000 төг/
- 3-р байр Ш.Амарбат Хархорин сум /50.000 төг/



40-49 насны эмэгтэй

- 1-р байр Б.Энх – Отгон Арвайхээр сум /70,000 төг/
- 2-р байр Г.Сонинбилэг Хархорин сум /60.000 төг/
- 3-р байр С.Наранцэцэг Төгрөг сум /50.000 төг/



50-59 насны эрэгтэй

- 1-р байр Ц.Даваадавга Арвайхээр сум /70,000 төг/
- 2-р байр Ё.Норовсамбуу Баянгол сум /60.000 төг/
- 3-р байр Н.Дамдинсүрэн Хархорин сум /50.000 төг/



50-59 насны эмэгтэй

- 1-р байр Д.Үржинжаргал Хархорин сум /70,000 төг/
- 2-р байр А.Хашчулуун Арвайхээр сум /60.000 төг/
- 3-р байр Б.Дулмаажав Хужирт сум /50.000 төг/



60-аас дээш насны эрэгтэй

- 1-р байр Ц.Төмөр-Очир Арвайхээр сум /70,000 төг/
- 2-р байр Ц.Чимэддорж Хархорин сум /60.000 төг/
- 3-р байр М.Цэрэннадмид Уянга сум /50.000/



60-аас дээш насны эмэгтэй

- 1-р байр С.Бүзмаа Арвайхээс сум /70,000 төг/
- 2-р байр Ж.Бямбатогтох Баян-Өндөр сум /60.000 төг/
- 3-р байр Д.Одончимэг Гучин-Ус сум /50.000 төг/



Шатрын төрөлд:

40-өөс дээш насны эрэгтэй

- 1-р байр Ж.Ганболд Арвайхээр сум /70,000 төг/
- 2-р байр Н.Ганболд Бат-Өлзий сум /60.000 төг/
- 3-р байр Н.Чогийдавга Уянга сум /50.000 төг/



40-өөс насны эмэгтэй

- 1-р байр Т.Авирцэрэн Уянга сум /70,000 төг/
- 2-р байр Ц.Эрдэнэчимэг Төгрөг сум /60.000 төг/
- 3-р байр Б.Мөнхзул Хархорин сум /50.000 төг/



50-аас дээш насны эрэгтэй

- 1-р байр Д.Машбаяр Хархорин сум /70,000 төг/
- 2-р байр Г.Дамба Арвайхээр сум /60.000 төг/
- 3-р байр П.Нямдавга Уянга сум /50.000 төг/



50-аас дээс насны эмэгтэй

- 1-р байр Ш.Маяасүрэн Арвайхээр сум /70,000 төг/
- 2-р байр Д.Цэвэлсүрэн Хархорин сум /60.000 төг/
- 3-р байр Ц.Шинэдолгор Төгрөг сум /50.000 төг



Шагайн харвааны хурууны төрөлд:

- 1-р байр н.Эрдэнэбилэг ахлагчтай Арвайхээр сум /70,000 төг/
- 2-р байр Түмэнбаяр ахлагчтай ЗБУлаан сум /60.000 төг/
- 3-р байр Бямбасамдан ахлагчтай Хархорин сум /50.000 төг

Шагайн харвааны чавхны төрөлд:

- 1-р байр Нэргүй ахлагчтай Хужирт сум
- 2-р байр Мягмар ахлагчтай Арвайхээр сум
- 3-р байр Намхай ахлагчтай Хархорин сум



“Биеэн тэтгэн чийрэгжүүлэх” хийн дасгалын төрөлд:

- 1-р байр Ё.Цэцгээ ахлагчтай Арвайхээр сум
- 2-р байр Б.Энхтуяа ахлагчтай Баянгол сум
- 3-р байр О.Долгорсүрэн ахлагчтай Хархорин сум



Энэхүү наадмын онцлох үйл явдал нь үе үеийн төлөөлөл болсон ахмад тамирчид, соёлын гавъяатууд нэг дор цуглаж 5 өдрийн турш залуу насаа эргэн дурсаж хэдэн өдрийн турш

Орон нутгийн удирдлагуудад тус наадмыг 3-н жилд нэг удаа уламжлал болгон явуулж байх саналыг ахмадууд маань дэвшүүллээ.



Монголын Мастеруудын III наадмын тайлан

Ахмадаа дэмжих жилийн ажлын хүрээнд орон нутагтаа ахмад тамирчидаа дээдлэх тэднийг ирээдүй хойч үед нь сурталчлах зорилгоор Монголын мастеруудын 3-р наадам Өвөрхангай аймгийн Арвайхээр хотноо 2017 оны 9-р сарын 08-10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Тус наадам нь спортын 5-н төрөл 3-н насны ангиллаар 17 байгууллагын 482 тамирчин оролцлоо. тэмцээний зохион байгуулагчаар ММБТСХорооны болон орон нутгаас шүүгчид нийлсэн 42 хүний ажлын бүрэлдэхүүнтэй тэмцээнийг өндөр түвшинд зохион байгуулж ажиллаа.



Тус наадмын нээлтийн үйл ажиллагаа Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Аюушбаатарын талбайд боллоо. Нээлтэнд засаг дарга Г.Ганболд, засаг даргын орлогч ӨВ аймгийн Граунд гольфын холбооны тэргүүн О.Батжаргал, НБХэлтсийн дарга тус наадмын комиссын дарга МУГБагш, доктор Б.Мөнхжаргал, ММБТСХорооны ерөнхийлөгч МУГДасгалжуулагч Ч.Наранбаатар, БТСГазрын дарга Б.Энхтөр, ахмадын хорооны дарга Б.Баяртогтох, ӨВ аймгийн ММБТСХорооны тэргүүн Ч.Оюунсүрэн, ахмад тамирчдын төлөөлөлүүд оролцлоо.





Тэмцээний үеийн зурагнууд /Волейбол, Граунд гольф, Шатар, Ширээний теннис, хөнгөн атлетик/ гэсэн спортын 5-н төрлөөр өрсөлдлөө.



Шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааны зурагнаас:



ММБТСХ-ны Өвөрхангай аймаг дахь салбар хорооноос Нэг удаагийн цохилтын эзэн Алтан бөмбөг цомоор Эрэгтэй 10, эмэгтэй 14, нийт 24 тамирчныг шагнасан болно.

- Байгууллагын дүнгээр Ч.Оюунсүрэн ахлагчтай Өвөрхангай аймаг 1-р байр
- Д.Баатархүү ахлагчтай Баянзүрх дүүрэг 2-р байр
- Ц.Цэрэнханд ахлагчтай Хилчин баг 3-р байр
- МУГД Д.Жамсран ахлагчтай Баянгол дүүргийн Од клуб тусгай байрт шалгарч, цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав.

ЭХНИЙ БАЙРАНД ОРСОН БАГУУД



Тус наадмыг зохион байгуулахад туслалцаа үзүүлсэн аймгийн ИТХ, Засаг даргын тамгын газар, ахмадын хороо, ММБТСХорооны хамт олондоо талархаснаа илэрхийлье.

2010 оны МУ-ын ерөнхийлөгчийн 53-р зарлигийн дагуу БЧТТСорилыг 35-аас дээш насны иргэдээс 10%-ийн гүйцэтгэлтэй хамрагдсан.



УБ хотод болсон ММБТСХорооноос Граунд гольф, софт волейболын спортын сургагч багш бэлтгэх сургалтанд 2 хүнийг сургажгэрчилгээ авлаа.



Уралдаан тэмцээнд зарцуулсан төсөв

Д/д	Нэр төрөл	Хаанаас	Зарцуулсан төсөв	Нийт дүн
1	Граунд гольфын 3 удаагийн тэмцээнд	Граунд гольфын холбоо	1.000.000	1.000.000
2	ААШ Софт волейболын тэмцээнд	БТСГазар	200,000 480,000	680.000
5	III наадам	Аймгийн ИТХурал	8,000,000	8.000.000
6	НИЙТ ДҮН			9.680.000

ҮР ДҮН:

- Биеийн тамир, спортын салбарт шинээр хөгжиж буй төрлийг үйл ажиллагаанд татан оруулсанаар аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо нэмэгдэж спортод дур сонирхолтой болсон байна.
- Нийтийн биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулсанаар байгууллага хамт олны уялдаа холбоо сайжирч, эрүүл мэндээ бэхжүүлэх иргэдийн тоо өсөж, халдварт бус өвчний өвчлөл бууран хүн амын дундаж наслалт нэмэгдэнэ.
- Нийтийн цэнгээт бүжиг хийсэнээр хүн өөрөө хөдөлгөөний дутагдалд орох, сэтгэлээр унах, уур бухимдалтай болохоос сэргийлэх, өөрийн биеэ нөхөн сэргээж эрүүл мэндээ сайжруулах зорилгоор нийтийн бүжиг бүжиглэдэг хүмүүс олон болсон байна.

Цаашид хийх ажил:

- Өвөрхангай аймгаас төрөн гарсан үе үеийн ахмад тамирчдын судалгаа гарган архивжуулах.
- Шинээр хөгжиж буй спортыг илүү түлхүү орон нутагтаа хөгжүүлэх
- Улсын болон тив, дэлхий тэмцээнүүдэд тамирчид бэлтгэн оролцуулах
- Тогтмол идэвхтэй хөдөлгөөн хийх ач холбогдлыг сурталчлах, иргэдийн оролцоо оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн хүн амын янз бүрийн бүлэг, хэсгүүдийн хамтын ажиллагааг улам сайн бэхжүүлэх, эрүүл мэндийг дэмжих бодит орчин бүрдүүлэх ХБӨ-ийн эрсдэлийг бууруулах ба түүний сөрөг үр дагаварыг багасгах зорилгоор бүх нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах

ТАЙЛАН БИЧСЭН:

НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН АРГА ЗҮЙЧ

Ч.ОЮУНСҮРЭН